

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/001/НА-СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он	Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 7056-2112, Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Аудитор: М.Ухаанбилэг Утас: 7058-4204, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-6
3. Аудитын илрүүлэлт	10
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СС	Сангийн сайдын
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.25 № 249
танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН
САНГИЙН ХЭЛТИЙН ДАРГА
В.ЦЭНГЭЛМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн, нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон онцлох асуудал үйл явдал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

• 232510245

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,785,533,099.97	860,496,112.91
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,785,533,099.97	860,496,112.91
3	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,785,533,099.97	860,496,112.91
4	Төгрөг	2,785,533,099.97	860,496,112.91
5	Төрийн сангийн харилцах	2,785,533,099.97	860,496,112.91
6	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,785,533,099.97	860,496,112.91
7	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,785,533,099.97	860,496,112.91
8	Засгийн газрын хувь оролцоо	2,785,533,099.97	860,496,112.91
9	Хуримтлагдсан үр дүн	2,785,533,099.97	860,496,112.91
10	Өмнөх үеийн үр дүн	969,060,182.47	2,785,533,099.97
11	Тайлант үеийн үр дүн	1,816,472,917.50	(1,925,036,987.06)
12	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,785,533,099.97	860,496,112.91

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,623,040,233.00	11,308,472,605.14
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,220,000,000.00	2,611,666,352.00
3	Нийтлэг татварын бус орлого	-	11,866,352.00
4	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		11,866,352.00
5	Тусламжийн орлого	3,220,000,000.00	2,599,800,000.00
7	Хандив тусламж /гадаад/	3,220,000,000.00	2,599,800,000.00
8	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,403,040,233.00	8,696,806,253.14
9	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,403,040,233.00	8,696,806,253.14
10	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	9,403,040,233.00	8,696,806,253.14
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,623,040,233.00	11,308,472,605.14
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,806,567,315.50	13,233,509,592.20
13	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	10,806,567,315.50	13,233,509,592.20
14	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,816,472,917.50	(1,925,036,987.06)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	12,623,040,233.00	11,308,472,605.14
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,623,040,233.00	11,308,472,605.14
3	Нийтлэг татварын бус орлого	-	11,866,352.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	11,866,352.00
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		11,866,352.00
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,220,000,000.00	2,599,800,000.00
7	Хандив тусламж /гадаад/	3,220,000,000.00	2,599,800,000.00
8	Орон нутгийн төсвөөс санхүүжих	9,403,040,233.00	8,696,806,253.14
123002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	9,403,040,233.00	8,696,806,253.14
9	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,623,040,233.00	11,308,472,605.14
11	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,758,936,715.50	13,233,509,592.20
12	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,758,936,715.50	13,233,509,592.20
13	Дотоод эх үүсвэрээр	10,758,936,715.50	13,233,509,592.20
14	Бусад хөрөнгө	10,758,936,715.50	13,233,509,592.20
15	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(10,758,936,715.50)	(13,233,509,592.20)
16	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,864,103,517.50	(1,925,036,987.06)
17	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	921,429,582.47	2,785,533,099.97
18	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,785,533,099.97	860,496,112.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	969,060,182.47	0.00	969,060,182.47
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	969,060,182.47	0.00	969,060,182.47
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,816,472,917.50	0.00	1,816,472,917.50
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,785,533,099.97	0.00	2,785,533,099.97
5	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,785,533,099.97	0.00	2,785,533,099.97
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,785,533,099.97	0.00	2,785,533,099.97
7	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,925,036,987.06	0.00	-1,925,036,987.06
8	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	860,496,112.91	0.00	860,496,112.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	ЗГСУМС гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,492,432,900.00	13,233,509,592.20	13,233,509,592.20	-
2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,492,432,900.00	13,233,509,592.20	13,233,509,592.20	0
3	Дотоод эх үүсвэрээр	15,492,432,900.00	13,233,509,592.20	13,233,509,592.20	0
4	Бусад хөрөнгө	15,492,432,900.00	13,233,509,592.20	13,233,509,592.20	0
5	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	15,492,432,900.00	11,308,472,605.14	11,308,472,605.14	0
6	ОРОН НУТГИЙН ТӨСВӨЭС САНХҮҮЖИХ	8,938,455,300.00	8,696,806,253.14	8,696,806,253.14	0
7	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	8,938,455,300.00	8,696,806,253.14	8,696,806,253.14	0
8	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,724,977,600.00	11,866,352.00	11,866,352.00	0
9	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		11,866,352.00	11,866,352.00	0
10	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,724,977,600.00			0
11	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	3,829,000,000.00	2,599,800,000.00	2,599,800,000.00	0
12	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	3,829,000,000.00	2,599,800,000.00	2,599,800,000.00	0
13	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,785,533,099.97		0
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	860,496,112.91		0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 578.2 сая төгрөгийн зөрчилд¹ нэг зөвлөмж өгөв.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт 93 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээс 7 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй нь орлого буурсан, тендерт оролцогч ирээгүй зэргээс шалтгаалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн “41.2.7.хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний хүрэх үр дүнг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ”. Харин зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хангаж ажиллаагүй	1	578.223.0	-	-	-	-	1	578.223.0	-	-	-	-
Дүн	1	578.223.0	-	-	-	-	1	578.223.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-	-	-	-